

“УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТЫН НЭГДСЭН ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД 2020 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2020 оны 12 сарын 12

Мандалговь хот

№	Зохион байгуулах сургалт	Сургалтын хэлбэр	Хамрагдсан албан хаагчид	Хэрэгжилт
1	2	3	4	
Нэг. Бүртгэлийн үйл ажиллагаа болон, архив албан хэрэг хөтлөлт, компьютер, албан хаагчдын ур чадварыг сайжруулах чиглэлээр зохион байгуулах сургалтын хэрэгжилт				
1	Иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн актуудыг нэг мөр ойлгох, хэрэгжүүлэх	-Онлайн -Танхим	Давхар тоогоор 115	Улсын бүртгэлийн Ерөнхий газраас Иргэний улсын бүртгэлийн шинэчилсэн систем хэрэглээнд нэвтрүүлэх гэж байгаатай холбогдон улсын ахлах бүртгэгч нарт онлайн сургалтыг зохион байгуулсан. Сургалтын хүрээнд сумдын бүртгэгч нартай онлайнаар холбогдон шинэчилсэн системээр туршилтын бүртгэлийн хийх талаар заавар зөвлөмж өгч нэг бүртгэгч туршилтын хугацаанд өдөрт 5 бүртгэлийг бүртгэх талаар үүрэг даалгавар өгч ажилласан. Туршилтын бүртгэл хийх явцад гарч байгаа алдаа зөрчил, санал хүсэлтээ тухай бүр УБЕГазарт хүргүүлсэн. Нийт 2 удаагийн туршилтаар 230 бүртгэлийг бүртгэсэн байна. Бүртгэгчдэд онлайнаар 3, танхимаар 2 удаа сургалт өгсөн.
2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн актуудыг нэг мөр ойлгох, хэрэгжүүлэх	-Онлайн -Танхим	3	Эд хөрөнгийн бүртгэлийн тасгаас Баянхонгор, Архангай, Хөвсгөл, Говь-сүмбэр, Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчид цахимаар уулзалт хийж, туршлага солилцон, эргэлзээтэй бүртгэлээр харилцан ярилцлага зохион байгууллаа. Шинээр баригдсан орон сууцанд иргэд хооронд захиалгын гэрээ хийхдээ зарим тохиолд улсын комисс хүлээн авсны дараа захиалгын гэрээ хийж бүртгүүлэхээр орж ирсэн тохиолдолд ямар гэрээгээр бүртгэгдэж байгаа, өв залгамжлал,


				<p>хамтран өмчлөгч хасах хэлцэл хоёрыг хамт буюу салгаж хүлээн авч бүртгэл хийж байгаа эсэх, барьцаалбар гээгдүүлж үрэгдүүлсэн эсэх, анхны бүртгэлийн болон бусад бүртгэлийн нотлох баримтыг хэрхэн бүрдүүлж байгаа, хаягийн асуудлыг яаж шийдэж бүртгэл хийж байгаа талаар асуулт асууж бусад аймгуудын туршлагыг сонсож ярилцсан нь үр дүнтэй сургалт боллоо.</p>
3	<p>Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн актуудыг нэг мөр ойлгох, хэрэгжүүлэх</p>	<p>- Онлайн - Танхимаар</p>	<p>Давхардсан тоогоор 46</p>	<p>- Татварын тухай хуульд өөрчлөлт орсны дагуу хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн Улсын бүртгэлийн хэлтэст батлагдсан маягтын дагуу мэдүүлэх болсонтой холбогдуулан улсын хэмжээнд бүртгэлтэй байгаа 194 мянга гаруй хуулийн этгээд нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгэхэд анхаарах асуудал, бүрдүүлэх материал зэрэг сэдвээр сургалт хийлээ. “Эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгэх, сумдад энэ ажлыг хэрхэн зохион байгуулах, Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайланг авах талаар заавар, зөвлөмж өглөө.Сургалтын онлайнаар 2 удаа, танхимаар 1 удаа, Ажлын байран дээр 1 удаа тус тус хийсэн.</p>
4	<p>Бүртгэлийн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, цаашид авах арга хэмжээ</p>	<p>- Онлайн - Танхимаар</p>	<p>22</p>	<p>Тайлангийн хугацаанд нийт 2296 бүртгэлд хяналт хийж 594 зөрчил илрүүлэн ажилласан байна Эд хөрөнгийн бүртгэлийн газраас эд хөрөнгийн эрхийн улсын</p>





				<p>бүртгэлийн гэрчилгээг үрэгдүүлснийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүй болгох шинэчилсэн зохицуулалт хийгдэж байгаа талаар сургалтыг хийж, эд хөрөнгийн бүртгэгч нарт заавар, зөвлөмж өглөө. 2019 оны ИГББүртгэлийн анхан шатны нотлох баримт, журнал бүртгэл хөтлөлт, бүртгэлд гарч байгаа алдаа зөрчил, анхаарах асуудал сэвдээр сургалт мэдээлэл хийж зөвлөн туслах үйлчилгээг хүргэж ажиллалаа. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгэл хийх явцад ургийн овог, нэр, хаяг зөрүүтэй бүртгэсний улмаас хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарах шаардлагатай байдаг иймд бүртгэл хийхдээ онлайнд шалгах, иргэний бичиг баримттай тулган бүртгэл хийж байхыг анхаарууллаа.</p>
5	Компьютерийн зарим хэрэглээний програмын талаар	Ажлын байран дээр	28	<p>Албан хаагчдын танхимын сургалт дээр сумдын улсын бүртгэгч нарт Dell нотебүүк компьютерт хэрэгцээгүй файлуудыг устгаж цэвэрлэн, файлуудыг эмх цэгцтэй фолдор үүсгэн хадгалж, өөрийн хэрэглэж байгаа компьютер тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хэрхэн ханган ажиллах талаар заавар зөвлөмж өглөө. Мөн иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан иргэдийн бүртгэлийг сүлжээгээр хэрхэн хуулж ирүүлэх, архивын программ, зураг тулгалтын программ, гэрчилгээ дахин хэвлэлтийн программ ашиглалтын талаар мэдээлэл өглөө</p>
6	Албан хэрэг хөтлөлтийн төрөлжсөн сургалтуудад хамруулах	Танхимаар	8	<p>- Боловсрол соёл урлагийн газраас төрийн албан хаагчдад зориулсан монгол хэл бичгийн модуль сургалтыг зохион байгуулсан бөгөөд энэхүү сургалтад хэлтсийн 8 албан хаагч өөрсдийн зардлаар сурч зөв бичгийн дүрэм, хэрэглээ болгох, албан бичгийн найруулга, албан бичгийн стандарт, төрийн албан хэргийн хөтлөлт гэсэн 3 чиглэлээр</p>

				сургалтанд хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлэхийн 2020 оны төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, сарын тайлан бусад холбогдох бичиг баримтыг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу хөтлөж, тайлан төлөвлөгөөг зөв бичгийн дүрмийн алдаагүй бичихэд анхаарч toli.gov.mn сайт, болон монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь зэргийг ашиглан бичиж байх талаар албан хаагчдад зөвлөлөө.
7	Шинээр томилогдсон албан хаагчдыг ажлын байранд мэргэшүүлэх дадлага сургалт	Танхимаар, ажлын байран дээр	4	2020 онд шинээр томилогдсон Өлзийт, Адаацаг, Дэрэн сумдын улсын бүртгэгчдийг ИГББүртгэл хөтлөхөд анхан шатны нотлх баримт хэрхэн бүрдүүлэх, онлайн программ дээр хэрхэн бүртгэл хийх, онлайн орчинд ажиллах дадлага суулгах, мэдлэг олгох зорилгоор аймгийн төвийн Сайнцагаан сумын улсын бүртгэгч Ш Чулууны ажлын байран дээр 7 хоногийн, улсын бүртгэгч Ш Чулуунжаргал иргэний бүртгэлийн онлайнаас ИГББүртгэлийн лавлагаа хэрхэн хайх, гаргах, лавлагаа олгоход анхаарах асуудлын талаар дадлага, мэдлэг олгох ажлын байрны сургалтыг танхимаар явууллаа.
Хоёр. Монгол улсын их хурлын болон орон нутгийн ээлжит сонгууль болохтой холбогдуулан зохион байгуулах сургалт				
8	Сонгуулийн тухай хууль, эрх зүйн зохицуулалтыг танилцуулах сургалт	Онлайн Танхим	135	Итгэмжлэгдсэн ажилтны хууль эрх зүйн сургалт, сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг хүргэх сургалт мэдээллийг тус тус зохион байгууллаа. МУИХ, АНСДИТХурлын сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтнуудын сургалтыг Онлайнаар 5 , танхимаар 3 удаа нийт 8 удаа зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 270 албан хаагчид хамрагдсан байна.
9	Сонгуульд ашиглах тоног төхөөрөмж, програмын сургалт	Онлайн Танхим	130	Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирсэн сургалтын баг МУИХурал, АНСДИТХурлын сонгуулиар ажилласан 116

				итгэмжлэгдсэн ажилтны программын сургалтыг 2 удаа танхимаар зохион байгуулсан. Сургалтаар тоног төхөөрөмж дээр хэрхэн ажиллах, анхаарах асуудал, СНЖагсаалт хэвлэх, өөрчлөлтийг лавлагаагаар тусгах, сонгуулийн өдөр ирц бүртгэлийн программаас сонгогчийн бүртгэлийн хуудсыг хэрхэн хэвлэх, мэдээ тайланг цаг хугацаанд нь дамжуулах зэрэг сэдвийн хүрээнд явуулсан.
Гурав. Байгууллагын үйлчилгээний стандарт, харилцаа хандлага, төрийн албан хаагчийн манлайллын хүрээнд зохион байгуулах сургалт				
10	Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцааны соёл, сахилга хариуцлага, манлайллын чиглэлээр сургалт зохион байгуулах	Онлайн, Танхимаар	28	-Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн хүрээнд улсын бүртгэлийн хэлтсээс нийт албан хаагчиддаа Аймгийн тэргүүлэх аудитор П Төвсанаагаар „Иноваци, хандлага, минимализм „ сэдэвт сургалт авлаа. Тус сургалтад сумдын улсын бүртгэгч нарыг онлайнаар хамрууллаа. Минималист байдлаар амьдарна гэж юу вэ, амьдралд хэрэг болохгүй зүйлс рүү шунах, өөрт шаардлагагүй ажил руу анхаарлаа төвлөрүүлэхээс эсрэг цөөн зүйл дээр төвлөрөх, энгийн, бага зүйлээр ихийг бүтээх, багаар их боломж үүсгэх зэрэг ойлголтоор илэрхийлж болох, иноваци буюу мэдлэгийг хэрхэн баялаг болгох, хандлага гэж юу вэ, эерэг сөрөг хандлага, хандлага харилцааны талаар сонирхолтой мэдээллийг өгсөн сайхан сургалт болсон.
Дөрөв. Амьдралын зөв хэвшил эрүүл мэндийн чиглэл, амралт чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх спортын төрөлжсөн сургалтууд зохион байгуулах хүрээнд				
11	Эрүүл мэнд, спортын чиглэлээр төрөлжсөн цуврал сургалтуудад хамруулах	Клуб, дугуйланд хамрагдах	9	Хэлтсийн эмэгтэйчүүд илүүдэл жингээ багасгах, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, зөв зохистой хооллож эрүүлээр илүүдэл жингээс салахад анхаарч ажлын байрны дасгал, хөдөлгөөнт аэробикыг хийх өөрийн эрүүл мэнддээ анхаарч байна. Хэлтсийн нийт албан хаагчид 11 сард эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх

				үзлэгт хамрагдах байсан боловч цаг үеийн байдалтай холбоотой хамрагдаж чадаагүй.
Тав. Авлигын эсрэг үйл ажиллагаа, гэмт хэрэг терроризмоос урьдчилан сэргийлэх, жендерийн эрх тэгш байдлыг хангах ажлын хүрээнд				
12	Авлигын эсрэг үйл ажиллагаа, ёс зүй ашиг сонирхол, шударга ёсыг эрхэмлэх чиглэлээр мэдлэг чадвар сайжруулах сургалт	Танхимаар	28	<p>Авлигын эсрэг олон улсын өдөр,-ийг угтан Зөв зөвд шударга зөв сэдэвт соён гэгээрүүлэх аяны хүрээнд тус аймаг уриалгад нэгдэж авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж авлигагүй, хүнд сурталгүй Дундговь авлигагүй хөгжинө уриалгад төрийн нэгдэхийг байгууллагуудыг нэгдэхийг уриалсан. Дээрх уриалгуудад Улсын бүртгэлийн хэлтэс нэгдлээ. Төрийн байгууллага, албан тушаалтан өдөр бүрийн үйл ажиллагаандаа шударга ёс, ил тод, нээлттэй байдлыг эрхэмлэн дээдэлж авлига, хүнд сурталгүй хамт олон байж, авлигын эсрэг хууль тогтоомж, авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаж буй талаар иргэдэд байгууллагын “Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс” фэйсбүүк групп болон нэг цэгийн үйлчилгээний танхимын LD зурагтаар мэдээ, мэдээллийг түгээлээ.Хэлтсийн бүх компьютерт “Авилгагүй бүс” санамжыг санаачлан нааж байрлуулан өдөр тутмын үйлчилгээ авч буй иргэдэд мэдээллийг хүргэсэн. Мөн “Авилгалыг мэдээлэх дугаар 110”, “Авилгагүй бүс” санамж тараалаа.</p> 
	Гэмт хэрэг, болзошгүй халдлагаас урьдчилан сэргийлэх сургалт	-Үзүүлэх сургалт -онлайн	13	Гэмт хэрэг болзошгүй халдлагаас урьдчилан сэргийлэх үзүүлэх сургалт зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгагдсан боловч цаг үеийн байдлаас болж хийж чадаагүй. Харин УБЕГазрын хамтын ажиллагаа сургалтын хэлтсээс онлайнаар зохион байгуулсан Засгийн газрын ,,

				Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай „ 01 дүгээр албан даалгаврын 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор хүүхдийн эрхийн хамгааллын асуудал сэдвээр сургалтыг явууллаа. Сургалтаар хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах тухай хүний эрхийн комисс, ахлах реферэнт Ц Адъяахишиг Хүүхдийн эрх ба хамгаалал, байгууллагын эцэг эхийн зөвлөл хэрхэн ажиллах 2020 оны төлөвлөгөө гаргасан эсэх талаар мэдээлэл солилцон сургалт мэдээллийг хийлээ. Сургалтад хэлтсийн албан хаагчид хамрагдлаа.
13	Жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулах	Танхимаар	28	Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд УБЕГазар нэгдэг гэртээ байгаа энэ цаг мөчид гэр бүлдээ, хайртай бүхэндээ цаг гарган, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, айдасгүй амар амгалан орчинг бий болгоход дуу уриалгад нэгдлээ.
Зургаа. Бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчилах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх				
14	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдэд эрх зүйн сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх	Уулзалт, ярилцлага, биечлэн өгөх зөвөлгөө, өдөрлөг, бусад хэлбэрээр	80	ХААН банкны төвийн 30 албан хаагч, 2020 оны 11 сарын 05-нд сумдын салбарын эрхлэгч 15 албан хаагч нарт “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэх, бүртгэл хийх явцад гарч байгаа хүндрэл, мэдээлэл хэрхэн авах зэрэг тодорхой мэдээлэл өглөө. Иргэдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэх, эрхэлсэн
				

				ажилдаа шинэ санал санаачлага нэвтрүүлэх, бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б. Одонтунгалаг “Бүртгэгч багш” өдөрлөгийг “Говийн-Ирээдүй” сургуулийн 10,11 дүгээр ангийн 40 сурагчид, багш нарыг оролцуулан зохион байгууллаа. Бүртгэлийн хууль тогтоомжийн талаар гарын авлага тарааж 25 багш ажилтнаас бүртгэлийн үйлчилгээний талаар болон байгууллагатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааг санал асуулгын хуудсаар авсан байна.
Найм. УБЕГазар, аймгийн ЗДТГазар, бусад холбогдох төрийн байгууллагаас зохион байгуулах сургалтанд хамрагдах чиглэлээр				
15	УБЕГазраас зохион байгуулах сургалтанд хөтөлбөрийн дагуу тухай бүр хамрагдах	Онлайн Танхимаар	78	<p>2020 онд УБЕГазраас онлайнаар зохион байгуулсан 18 сургалтад нийт давхардсан тоогоор 78 албан хаагч хамрагдсан. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгэх, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй, удирдах ажилтны сургалт,архив албан хэрэг хөтлөлт, иргэний шинэчилсэн систем, хууль эрх зүйн сургалт, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах, УИХ, АНСДИТХ-ын сонгуулийн тухай хууль тогтоомж зэрэг сэдвүүдээр сургалтад хэлтсийн албан хаагчдыг хамрууллаа. Итгэмжлэгдсэн ажилтны ирц программын сургалтыг танхимаар тус тус зохион байгууллаа. МУИХ, АНСДИТХурлын сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтнуудын сургалтыг Онлайнаар 5 , танхи маар 3 удаа нийт 8 удаа зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 270</p>
				

				албан хаагчид хамрагдсан байна.
16	Аймгийн ЗДТГазар, бусад эрх бүхий байгууллагаас зохион байгуулах сургалт мэдээлэл	Танхим Онлайн	Давхардсан тоогоор нийт 6	Аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан төрийн албан хаагчдын ёс зүйн зөвлөгөөн, мерит төслөөс хэрэгжүүлсэн Дундговь аймгийн хүний нөөцийн суурь судалгааны үр дүнгийн танилцуулах хэлэлцүүлэг, гүйцэтгэлийн тайланг хэрхэн үнэлэх, архив албан хэрэг хөтлөлт, менежерүүдэд зориулсан манлайллын сургалт, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд нийгмийн ажилтнуудыг зорилтот бүлгийн иргэдэд илүү чанартай үйлчлэхэд туслах харилцагчийн үйлчилгээний системийн шийдэл сэдэвт сургалтуудад холбгдох албан хаагчид хамрагдлаа . Танхимын 3, онлайнаар 3 нийт 6 удаагийн сургалт явагдсан байна.

---ooOOOoo--